

ТАНИЛЦУУЛГА /Дэлгэрэнгүй/

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан, Хүний эрхийн Үндэсний Комиссоос боловсруулсан Хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлүүдэд тусгасан жагсаал цуглааны талаарх судалгаа мэдээлэл дүгнэлт мэдээлэл, зөвлөмж, “Эмнести интернэшнл” төрийн бус байгууллагаас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн сайжруулахтай холбоотой тус байгууллагаас хийсэн дүгнэлт, тайлан, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 оны 12 сард зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, түүнчлэн нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зарим асуудал болон бусад материалыг үндэслэн хуулийн төслийг боловсрууллаа.

Ийнхүү жагсаал, цуглаан болон түүний төрөл, хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрсөн агуулгаар шинээр томьёолох, жагсах, цуглах эрх чөлөөнд үндэслэлгүйгээр хязгаарлалт тавихгүй байх, Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдаагүй аяндаа үүссэн жагсаал, цуглааны талаарх зохицуулалт, түүнчлэн жагсаал, цуглаан хийх мэдэгдэл хүргүүлэх, бүртгүүлэх үйл ажиллагаанд дэвшилтэд зохицуулалт бий болгох, хууль сахиулах, нийгмийн дэг журмыг хангах чиг үүрэг бүхий байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тодорхой болгох зэрэг зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад тайван хуран цуглах эрхийг баталгаажуулан заасан байдаг бөгөөд ингэхдээ тайван болон тайван бус жагсаал, цуглааныг ялгаатай байдлаар ойлгож пактын хүрээнд зөвхөн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хамгаалдаг. Иймд хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгөд эрсдэл учруулахуйц байдлаар зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тайван бус гэж, үүнээс бусдаар тааламжгүй нөхцөл байдалтай байсан ч хүмүүс хүлцэх боломжтой нөхцөл байдал бүхий жагсаал, цуглааныг тайван гэж тус тус тодорхойлсон.

Мөн иргэд хуран цуглаж үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд, энэ нь олон төрлийн хэлбэрээр илрэн гарч болдог тул хоёр ба түүнээс дээш тооны хүн ижил зорилгоор нийтийн эзэмшил эсхүл, хувийн өмчлөлийн газарт цуглаж, үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлж байгаа үйл ажиллагааг цуглаан гэж, хоёр ба түүнээс дээш тооны хүн хот, суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлэх үйл ажиллагааг жагсаал гэсэн агуулгаар тус тус томьёолж, харин жагсаал, цуглааныг суулт, өлсгөлөн зарлах болон хуулиар хориглоогүй бусад хэлбэрээр зохион байгуулж болохоор тусгаад байна.

Хуулийн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зарчим шийдвэрлэх нөлөө үзүүлж, тэдгээрийн гол эх үндэс нь болдог¹ талаар судлаачид дүгнэсэн байдаг. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд үйл ажиллагаандаа баримтлах зарчим тусгагдаагүй байдаг. Иймд хуулийн төсөлд тайван жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх болон хууль сахиулах байгууллагаас нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна ялгаатай үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх, үндэсний нэгдмэл байдлыг хангах, бусдын эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэх, хүчирхийллээс ангид байх, мэдээлэл нээлттэй, ил тод байх зэрэг зарчмуудыг тусгалаа.

Түүнчлэн тус хууль нь төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа хүндэтгэл болон ёслолын жагсаал, цуглаан, хүн, хуулийн этгээдээс зориулалтын байгууламж болон олон нийтийн газар зохион байгуулж байгаа спорт, урлаг, соёл урлаг, үзэсгэлэн худалдаа, бизнесийн үйл ажиллагаа болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ, төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээдээс зохион байгуулж байгаа хурал, уулзалт, хэлэлцүүлэг, мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэх өдөрлөг болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ, улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчээс иргэн, сонгогчидтой, төрийн бус байгууллагаас гишүүн, дэмжигчидтэй хийх хурал, уулзалт зэрэгт хамаарахгүй байхаар тусгалаа.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд төрийн ёслолын болон төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, цуглаанд тус хууль хамаарахгүй байхаар заасан. Энэ нь жагсаал цуглааныг бүртгэнэ гэсэн зохицуулалттай боловч төрийн байгууллага өөрөө бүртгүүлэхгүй хийж болохоор зохицуулсан байгаа талаар 2004 оны Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх 3 дахь илтгэлд дурдагдсан байдаг. Иймээс төрийн байгууллагаас зохион байгуулсан жагсаал, цуглаан гэх хэт ерөнхий, ойлгомжгүй зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээдээс зохион байгуулж байгаа хурал, уулзалт, хэлэлцүүлэг, мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэх өдөрлөг болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ нь жагсаал, цуглаанд хамаарахгүй байхаар өөрчлөн тусгасан.

Хүчин төгөлдөр Жагсаал, цуглаан хийх эрхийн тухай хуульд жагсаал, цуглаан хийх эрхийг зөвхөн тодорхой тооны этгээд санаачлах, зохион байгуулах агуулгаар буюу Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй байхаар заасан. Өөрөөр хэлбэл эдгээр этгээдээр хязгаарлаж байгаа нь олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцыг зөрчсөөр байна. Иймээс хуулийн төсөлд хүн, хуулийн этгээд, эрх зүйн харилцаанд оролцогч

¹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол УБ 2020 он 50 дахь тал

бүх этгээд санаачлах, зохион байгуулах, оролцох эрхтэй байхаар өргөжүүлэн тусгалаа.

Түүнчлэн хүчин төгөлдөр хуульд жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ийнхүү тухайлан сэдэв, асуудал тусгахгүйгээр ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй тусгаад байна.

Жагсаал, цуглаан хийх хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх

Тайван хуран чуулах эрх чөлөөг хэрэгжүүлэх хууль ёсны арга хэлбэрүүд буюу аяндаа үүссэн цуглаан, давхацсан ба эсрэгцсэн, давталттай цуглаан, үл захирагдахуйн акц зэргийг хуульд тусгахыг Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлээрээ зөвлөсөн байдаг.

Тодорхой үйл явдал болсон даруйд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх боломжгүй, тодорхой зохион байгуулагчгүй жагсаал, цуглаан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдгийг манай улс хориглож, бүртгүүлээгүй гэх үндэслэлээр хууль бусад тооцох тохиолдол гарсаар байна. Иймд “аяндаа бий болсон жагсаал”-ыг цагдаагийн байгууллага мэдэгдэл хүргүүлсэн жагсаалын адил хүлээн зөвшөөрч, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журам хамгаалах зэрэг үүрэг хүлээхээр тусгасан. Ийм төрлийн жагсаалд заавал мэдэгдэл хүргүүлэхийг шаардах, зохион байгуулагчтай байхыг шаардах боломжгүй юм. Харин жагсаал, цуглааны явцад зохион байгуулалтад орох тохиолдол байдаг тул энэ тохиолдолд хамгийн боломжит хурдан хугацаанд зохион байгуулагч нь эрх бүхий байгууллагад мэдэгдэх зохицуулалтыг тусгалаа. Энэ нь аяндаа үүссэн гэх шалтгаанаар нийтийн эмх замбараагүй байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд нэмэр болох, цаашлаад иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлэх зорилготой.

Хүчин төгөлдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар зохих журмын дагуу бүртгэгдсэн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийхийг хориглосон байдаг. Харин хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ижил асуудлаар, тухайн цаг хугацаанд өөр өөр газарт, эсхүл өөр асуудлаар ижил газарт жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй, жагсаал, цуглаан зохион байгуулж байгаа тухайн асуудлын эсрэг байр сууринаас үзэл бодлоо илэрхийлж жагсаал, цуглаан зохион байгуулах эрх, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй байхаар өөрчлөн тусгасан нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад дэвшилтэт зохицуулалт болно гэж үзэж байна.

Мэдэгдэх, бүртгэх тогтолцоо

Хуулийн төслийн нэгэн чухал зохицуулалт бол жагсаал, цуглаан хийхийн тулд аймаг, нийслэлийн Засаг даргаас бүртгэл нэртэй боловч бодит байдал дээр зөвшөөрөл авдаг байдлыг халах зорилгоор хуульд хориглохоор заасан байршлаас бусад газар жагсаал, цуглаан хийх бол цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсах, цуглах эрх нээлттэй болох юм. Өөрөөр хэлбэл, авто замын зорчих хэсэгт жагсаал, цуглааныг зохион байгуулахаар бол урьдчилан мэдэгдэж, хариу авсны үндсэн дээр, харин хуулиар хориглосноос бусад газар зөвхөн мэдэгдэл хүргэснээр буюу ямар нэг хариу хүлээх шаардлагагүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэх юм.

Ингэхдээ замын хөдөлгөөнд саад учруулах боломжтой, авто зам дээр жагсаал, цуглаан хийх бол бүртгүүлж, жагсаал, цуглаан хийж болох эсэх талаар хариу авахаар тусгасан. Учир нь ийм байршилд хийгдэх жагсаал, цуглаан нь тухайн бүс нутгийн автозамын хөдөлгөөнд оролцогч нийт иргэдийн өдөр тутмын амьдралд хамаарах асуудал болох тул хөдөлгөөнд зохицуулалт хийх, мэдээлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг судлах шаардлагын үндсэн дээр ирүүлсэн мэдэгдлийг хянах нь зүйтэй гэж үзсэн. Ийм зохицуулалт бүхий Эстони зэрэг орон бий.

Мөн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн дагуу бүх төрлийн жагсаал, цуглааныг бүртгэх зохицуулалт байдаг. Харин шинэ хуулийн төслөөр иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг илүү нээлттэй байдлаар зохицуулах зорилгын үндсэн дээр аяндаа үүссэн жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт зарлах, хуулиар хориглоогүй жагсаал, цуглааныг 30 хүртэлх буюу цөөн тооны оролцогчтойгоор зохион байгуулах зэрэг тохиолдлуудад мэдэгдэл хүргүүлэх шаардлагагүй байдлаар тусгаж өгсөн.

Түүнчлэн 2004 оны Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх 3 дахь илтгэлд жагсаал, цуглаан зохион байгуулах талаарх мэдэгдлийг Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан хүлээн авч бүртгэж байгаа нь субъектив хандлагыг бий болгож байгаа бөгөөд Засаг даргын бүртгэхээс татгалзах үндэслэл тодорхой бус байдаг явдал нь шүүмжлэл дагуулдаг талаар дурдсан.

Ийнхүү бүртгэх эрх бүхий субъект улс төрийн албан тушаалтан байгаа нь субъектив хандлага гаргах магадлалыг бий болгодог тул жагсаал, цуглааны үеэр тэдэнтэй хамгийн ойр ажилладаг, хууль сахиулах, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангуулах эрх бүхий байгууллага буюу цагдаагийн байгууллагад энэхүү эрхийг олгохоор тусгаад байна. Дэлхийн улс орнуудад энэ чиг үүргийг ихэнх тохиолдолд хууль сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд ХБНГУ зэрэг улсуудад байдаг үр дүн бүхий зохицуулалт юм.

Хориглолт, хязгаарлалт

Хуулиар хориглох жагсаал, цуглааны агуулгад Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлд заасан дайныг аливаа хэлбэрээр сурталчилах, алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг

үндсэрхэг үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгаа хийхийг хуулиар хориглох гэх агуулгуудыг оруулж өгсөн. Түүнчлэн тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хориглох, хязгаарлах үндэслэл болдог Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд дурдсан дараах зорилгуудыг тусгасан.

- 1.үндэсний буюу нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах
- 2.нийгмийн дэг журмыг хангах
- 3.хүн амын эрүүл мэндийг хамгаалах
- 4.ёс суртахууныг хамгаалах
- 5.бусдын эрх эрх чөлөөг хамгаалах

Хүний эрхийн гэрээ, конвенцоор жагсаал цуглаан хийхийг хориглох, хүрээ хязгаарыг аль болох багасгах, бууруулах чиглэлд ажиллахыг зөвлөдөг бөгөөд дээр дурдсанчлан нийгмийн дэг журмыг хангах, үндэсний аюулгүй байдал, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах шаардлагаар зөвхөн хуулиар хориглолт, хязгаарлалтыг тавихыг хүлээн зөвшөөрдөг. Иймээс олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн өөрийн орны онцлогт тохирсон тодорхой хязгаарлалтыг тавих нь зүй ёсны хэрэг билээ. Манай улс жагсаал, цуглаанд байршлаар нь, зорилго, агуулгаар нь, субъектээр нь, цаг хугацаагаар нь хязгаарлалт тавьдаг хэдий ч зөвхөн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд бус, бусад хуулиудаар мөн тус хязгаарлалтуудыг зохицуулсан байна. Иймээс бусад хуульд заасан хориглосон, хязгаарласан зохицуулалтыг энэ хуулийн төсөлд нэгтгэн тусгах зарчмыг баримтласан тул энэ нь шинээр хориглолт, хязгаарлалыг нэмсэн асуудал огт биш бөгөөд зөвхөн хууль зүйн техникийн үүднээс нэгтгэсэн болохыг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал, байршлын хувьд Монгол Улсын хилийн боомт, нисэх онгоцны буудал, төмөр замын–өртөө, буудал, эмнэлгийн байгууллага, Төрийн ордон, түүний нутаг дэвсгэр, хорих анги, түүний хамгаалалтын зурвас, улсын онц чухал объект, төрийн тусгай хамгаалалтын байнгын бүс зэрэг газруудад хязгаарлахаар тусгаад байна.

Жагсаал, цуглаан шөнийн цагаар, их хэмжээний дуу чимээ гаргаж үргэлжлэх, авто замын хөдөлгөөн, хүний урсгалыг зохицуулах боломжгүйгээр удаан хугацаанд хааж, саатуулах зэргийг хуулиар хориглож болно. Харин энэ төрлийн зохицуулалт нь дор тайлбарлах хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах журамд нийцэх шаардлагатай талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлд /2023 он/ тусгасан байдаг. Гадаадын зарим орон тухайлбал, БНСУ-д зөвхөн нар мандахаас нар жаргах хүртэлх хугацаанд жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрдөг. Учир нь шөнийн цагаар үзэл бодлоо хүргэхээр зорьж байгаа этгээдийн ажил тарсан байх, олон нийтийн амгалан тайван байдал алдагдах, хүмүүсийн идэвхтэй байх хугацаа буурсан байх, харагдах орчин хязгаарлагдсан байх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлага нэмэгдэх зэрэг шалтгаан гардаг тул хориглодог байна.

Манай улсын хувьд жилийн 4 улиралтай, улирлаас хамааран нар жаргах, мандах хугацааны мөчлөг ихсэх, буурах үзэгдэл элбэг байдаг тул нарны гэрэл бус 06 цагаас 22 цаг хүртэл буюу шөнийн цагаар жагсахыг хориглох зохицуулалтыг бий

болгох нь зүйтэй гэж үзлээ. “Шөнийн цаг”-ийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасантай адил байдлаар авах нь зүйтэй гэж үзэн Хөдөлмөрийн тухай хуульд тайлбарласныг эш татах байдлаар тусгалаа.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд сэтгэцийн өвчтэй хүний жагсаал, цуглаанд оролцох эрхийг шууд бусаар хязгаарласан, сэтгэцийн өвчтэй хүн гэх ойлголтыг тодорхойлоогүй зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн холбогдогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийг зөрчсөн хэрэг болсон талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлд /2023 он/ дурдсан байдаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад хүмүүсийн нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах зорилгоор хуулийн төсөлд зөвхөн сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохоос хязгаарлах тухай агуулгыг нарийвчлан тодорхойлж өгсөн билээ.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа

Нийслэлийн Засаг дарга 2020 онд А/930 дугаар захирамж баталж Улаанбаатар хотын хэмжээнд цар тахлын хүрээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг шилжүүлсэн хугацаанд жагсаал, цуглаан хийхийг хориглож, олон жагсаал, цуглааныг тус захирамжид үндэслэн бүртгэхээс татгалзсан явдал нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хууль бусаар хязгаарласан үйлдэл болсон талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 20 дахь илтгэлд тусгасан байдаг. Түүнчлэн зарим төрийн захиргааны байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулж болохгүй хугацааг зааж, зарим хөшөөний дэргэд жагсаж, цуглаж байна гэх мэт шалтгаанаар зөвшөөрөл өгөхгүй байх тохиолдол олон гарсныг судлаачид, ялангуяа “Эмнэсти интернэшнл” төрийн бус байгууллагын “Цар тахалын үеийн хууль сахиулах ажиллагаа” сэдэвт судалгааны тайланд цагдаагийн байгууллага, албан хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдлын судалгааны дүгнэлт, тайланд тусгаж олон нийтэд мэдээлэх болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авсан байдаг. Иймд шинэ хуулийн төсөлд захиргааны актаар энэхүү эрхийг хориглосон хязгаарласан агуулгатай шийдвэр гаргаж, баталж мөрдүүлэхийг хориглох тухай тусгаад байна.

Түүнчлэн иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх нэг хэлбэр болох өлсгөлөнгийн зохицуулалт одоо үйлчилж байгаа практикт маш хангалтгүй зохицуулагдсан талаар Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн үр дагаврын үнэлгээ (2022 он)-нд дурдагдсан бөгөөд өлсгөлөн зарлах үед цагдаагийн болон эмнэлгийн байгууллагаас ямар чиг үүрэгтэй оролцох тухай нарийвчилсан зохицуулалт шаардлагатай гэдгийг онцолсон. Энэ хүрээнд өлсгөлөн зарласан этгээдийн эрүүл мэндийн байдалд нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллага үзлэг хийж, дүгнэлт гаргах, хэрэв өлсгөлөн зарласан этгээдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрахаар байгаа нь тус дүгнэлтээр тогтоогдсон бол нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн газрын дарга нь өлсгөлөнг зогсоож, албадан эмчилгээнд

оруулах арга хэмжээ авах шийдвэрийг гаргаж, эмнэлгийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулна гэх зохицуулалтыг оруулж өгсөн.

Хуулийн төсөлд мөн хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах зохицуулалттай холбоотой зохицуулалтыг тусгаад байна. Албадан тараах үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу зохион байгуулагдаж байгаа, хуулийн төсөлд тусгасан хууль бус үйл ажиллагаа бий болоогүй, аяндаа үүсэн шинжтэй, өлсгөлөн, суулт хэлбэрээр хийгдэж байгаа жагсаал цуглаанд хамааралгүй болно. Зөвхөн хуульд заасан үндэслэлээр, тараах үндэслэл гарцаагүй бий болсон нь тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд цагдаагийн байгууллагын шийдвэрээр тус арга хэмжээ авахаар тусгалаа. Ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах, урьдчилан сануулах, оролцогчдын хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, ийнхүү албадан тараасны дараа Хүний эрхийн Үндэсний Комисс болон цагдаагийн байгууллага хамтран олон нийтэд тус ажиллагааны талаар мэдээлэл өгдөг байх зохицуулалтыг тусгалаа.

Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага болох Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үүрэг оролцооны талаар зохицуулалт бий болгох нь зүйтэй гэж үзсэн болно.

Жагсаал, цуглаанд оролцогчдын эрх, үүрэг

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд жагсагчдын бүх үүргийг зохион байгуулагчид хүлээлгэхээр заасан байдаг. Хуулийн төсөлд Зохион байгуулагчид үүрэг болгосон хэсгийг боловсронгуй болгож жагсаалд оролцогчид өөрсдөө тодорхой үүрэг хариуцлагатай байх, шаардлагатай тохиолдолд зохион байгуулагч болон цагдаагийн байгууллага хамтран ажиллахаар тусгасан.

Үзэл бодлоо илэрхийлэн жагсаал, цуглаан зохион байгуулж байгаа болон оролцож байгаа этгээдүүдтэй цагдаагийн байгууллагын албан хаагчид хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхийг зорилоо.

Түүнчлэн жагсаал, цуглааны үйл явцад хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс жагсаал, цуглааныг сурвалжлах, мэдээллэх эрхэд хязгаарлалт тавихгүй байх агуулга бүхий заалт мөн шинээр тусгалаа. Жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг зөрчиж байгаа гэж үзсэн тохиолдолд тухайн байгууллагад дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргах, мөн Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй байхаар тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

